

Улаанбаатар, Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт байршилтай

**УУРЫН ЗУУХ БОЛОН НҮҮРСХҮЧЛИЙН ХИЙН
ҮЙЛДВЭРИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Компанийн регистрийн дугаар: 6423701

Хянасан:

Нийслэлийн БОГ-ын мэргэжилтэн _____

Биелэлтийг тайлагнасан:

Агар энерги ХХК-ийн Гүйцэтгэх захирал  Ц.Хүдэрхуяг

Агар энерги ХХК-ийн БОХАБ хариуцсан ажилтан  Б.Алтанхишиг

2023 он

АГУУЛГА

ОРШИЛ	1
УУРЫН ЗУУХ БОЛОН НҮҮРС ХҮЧЛИЙН ХИЙН ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
ҮЙЛДВЭРИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	6
ҮЙЛДВЭРИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	10
1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ АРИЛГАХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	11
2. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	13
3. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	13
4. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	14
5. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	17
6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН	18
7. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	19
8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	20
9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ЗАРДЛЫН ЗАДАРГАА	21
ХАВСРАЛТ 1. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН НҮҮР	22
ХАВСРАЛТ 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН БИЕЛЭЛТ	26
ХАВСРАЛТ 3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	39
ХАВСРАЛТ 4. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	41
ХАВСРАЛТ 5. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	59
ХАВСРАЛТ 6. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	63
ХАВСРАЛТ 7. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	68

ОРШИЛ

“Агар энержи” ХХК нь 2019 онд байгуулагдсан, Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хороо, Амгалан, Гачууртын зам 104/6 хаягт байрлан, М Си Эс кока кола үйлдвэрийг дулаанаар ханган, технологийн уур, хүнсний зориулалттай нүүрсхүчлийн шингэрүүлсэн хий үйлдвэрлэн тус үйлдвэрт нийлүүлдэг.

Агар энержи ХХК-ийн “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэрийн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний 13/5917 дугаартай БОАЖЯ-ны дүгнэлт 2020 оны 8 дугаар сарын 27-нд гарсан. Ерөнхий үнэлгээний дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Глобал энвайрон компаниар хийлгэсэн бөгөөд нарийвчилсан үнэлгээний тайлан болон 5 жилийн менежментийн төлөвлөгөө БОАЖЯ-аар 2021 оны 06 дугаар сарын 25-нд батлагдсан. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон 5 жилийн менежментийн төлөвлөгөөний нүүрийг Хавсралт 1-т үзүүлэв.

Энэхүү тайлангаар “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн аж ахуйн үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний 2023 оны гүйцэтгэлийг тайлагнасан болно.

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2023 оны 1 дүгээр сард БОАЖЯ-аар батлагдсан бөгөөд энэхүү төлөвлөгөөнд заасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэнийг энэ тайлангаар танилцуулж байна.

Агар энержи ХХК тайлант онд байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд 15,308,933 төгрөгийг зарцуулсан.

УУРЫН ЗУУХ БОЛОН НҮҮРС ХҮЧЛИЙН ХИЙН ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Агар энержи компанийн Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэр нь “М-Си-Эс Кока-Кола” үйлдвэрийг технологийн уур, халаалт, хэрэглээний халуун ус, хүнсний зориулалттай хийгээр хангах үйл ажиллагаа явуулдаг.


2019-2020 онд “М-Си-Эс Кока-Кола” компанийн ашиглаж байсан нүүрсээр ажилладаг хуучин зуухыг шингэрүүлсэн нефтийн хийгээр ажилладаг зуухаар сольж өөрчлөн шинэчилснээр тус үйлдвэрийг найдвартай, тасралтгүй уур, дулаан болон хүнсний зориулалттай хийгээр хангах, байгаль орчинд сөрөг нөлөө багатай үйлдвэрлэл явуулах боломжийг бүрдүүлсэн. Үйлдвэр 2020 оны 10 сард ашиглалтад орсноор

- М-Си-Эс Кока-Кола ХХК-ийн нүүрсээр ажилладаг зуухнуудыг орчин үеийн, ашигт ажиллагаа өндөртэй, шинэ зуухнуудаар шинэчилсэн.
- Үйлдвэрлэлийн технологийн процесст нэн шаардлагатай технологийн уур, нүүрсхүчлийн хийгээр найдвартай хангах боломж бүрдсэн.
- Уламжлалт түүхий нүүрсний хэрэглээг тэглэж, агаар болон орчинд хаягдах хорт бодис, нарийн ширхэглэгт тоосонцор буюу хатуу хог хаягдлыг байхгүй болгосноос гадна хүлэмжийн хийн ялгаралтыг үлэмж хэмжээгээр бууруулсан.
- Агаарын бохирдлыг бууруулах Засгийн газар, Нийслэлийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд хувь нэмрээ оруулж, олон улсын стандартын шаардлагад нийцсэн жишиг зуухны газар бий болсон.

Компанийн нэр, хаяг:

“Агар энержи” ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 9011391089
Регистрийн дугаар: 6423701
Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, олимп
19а, Шангри-Ла оффис 7 давхар, 704 тоот
Утас: 77226262,

“Агар Энержи” ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт байрших “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэр”-ийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан **2023**



Зураг.1. Үйлдвэрийн план зураг

Үйлдвэрийн тоног төхөөрөмж

Зуухны газар:

- 4 т/ц уур үйлдвэрлэх хүчин чадалтай БНСУ-ын DAEYEOL компанид үйлдвэрлэсэн DRH-400PG загварын нийт 4 ширхэг уурын зуух
- 0.63 гкал/ц хүчин чадал бүхий Япон улсын NTEC компанид үйлдвэрлэсэн HGTL-630A загварын нийт 8 ширхэг ус халаах зуух
- Зуухны хийн түлшийг дамжуулах “Юнигаз” ХХК-ийн импортын агуулах дахь хадгалах банкаас нийт 180 м урт, ф57 мм ган хоолой

- Шингэрүүлсэн байгалийн хийг буцаан хийн төлөвт шилжүүлэх ууршуулах төхөөрөмж
- Бусад тоноглолууд. Зуухны барилгад үндсэн уурын болон ус халаах зуухнаас гадна тэдгээрийн тэжээлийн усны насосууд, үлээлгийн бак, конденсат цуглуулах бак, тэлэлтийн сав болон тэдгээрийн хоорондын халуун ус ба уурын шугам хоолой, холбох хэрэгсэл, таслах болон тохируулах хаалтууд, хянах хэмжих хэрэгслүүдийн угсрагдсан. Мөн цахилгаан тэжээлийн болон удирдлагуудын угсралт, дохиоллын болон тэжээлийн кабель, кабелийн трассуудыг угсарч байрлуулсан.

Нүүрсхүчлийн хийн аж ахуй:

Энэ үйлдвэр нь нүүрсхүчлийн хийг (CO₂) олборлох, цэвэршүүлэх, шингэрүүлэх технологиор дэлхийд тэргүүлэгч болох Дани улсын Юнион инженеринг компанийн EBU 500 загварын иж бүрэн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон. Үйлдвэрт технологийн уур үйлдвэрлэх уурын зуухны шингэрүүлсэн нефтийн хийн шаталтаас ялгарах утааны хийнээс CO₂-г ялган авна. Үйлдвэр нь цагт 500 кг цэвэршүүлсэн CO₂ үйлдвэрлэх хүчин чадалтай. Үйлдвэрлэж буй CO₂-н цэвэршилт 99.99%-99.997% байдаг.

Үйлдвэрийн бүхий л үйл ажиллагаа автомат системээр хянагдан удирдагдах бөгөөд удирдлагын систем нь хамгийн сүүлийн үеийн PLC технологи болон TFT өнгөт самбарыг ашигладаг. Үйлдвэрийн удирдлагын самбар дээр үйлдвэрлэлийн явц, мэдээлэл гаран, хадгалагдах ба анхааруулах, мэдээлэх, дохио өгөх зэргээр бүх процессыг хянахаас гадна CO₂-н үйлдвэрлэлийн туршид болон хадгалах танк дахь бүтээгдэхүүнийг Герман улсын “CARBOSCAN 150” байнгын хяналтын төхөөрөмжөөр CO₂ дахь нийт 17 нэгдлийг тасралтгүй шинжилдэг.

ҮЙЛДВЭРИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Талбайн байршил

“Агар энержи” ХХК-ийн “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэрийн байршил нь Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт “М-Си-Эс Кока-Кола” ус ундааны үйлдвэрийн хашаанд байрладаг. Уг үйлдвэрийн газар нь Улаанбаатар хотын төвөөс 8 км-т байрлаж байна.

Хүснэгт.1. Газрын координат

№	X	Y	Цэгүүд	Урт
1	5310038.14	651071.54	1-2	21.57
2	5310058.78	651065.30	2-3	22.48
3	5310064.51	651087.03	3-4	134.87
4	5310195.16	651053.54	4-5	0.53
5	5310195.28	651054.06	5-6	48.94
6	5310242.61	651041.62	6-7	12.90
7	5310255.04	651038.18	7-8	102.91
8	5310281.23	651137.70	8-9	153.66
9	5310315.56	651287.48	9-10	57.06
10	5310259.00	651294.99	10-11	179.81
11	5310081.26	651322.17	11-12	220.07
12	5310025.00	651109.41	12-13	22.38
13	5310046.64	651103.69	13-1	33.25



Зураг.12. Үйлдвэрийн 1:30.000 масштабтай зураглалын (байршил) ерөнхий харагдах байдал



Зураг.3. Үйлдвэрийн зураг

Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт

“Агар энержи” ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт байрлах “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэрийн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт, болзошгүй нөлөөллийн хураангуйг энэ хэсэгт оруулав.

Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт	
Газрын гадарга, байр зүй	Судалгааны талбай нь геоморфологийн хэв шинжийн хувьд, уулын бэл хормойн хурдас чулуулгийн зөөгдөл-хуримтлалын гадаргуугийн хэсэгт хамаарагдана. Үйлдвэрийн газар нь далайн түвшнээс дээш 1312 м орших бөгөөд газарзүйн байрлал нь ХӨ 47°54'26,7", ЗУ 107°01'25,2" болно.
Уур амьсгалын нөхцөл	Монгол орны уур амьсгалын мужлалын хувьд авч үзвэл Улаанбаатар хот орчим нь хуурайдуу сэрүүвтэр мужийн нэн хүйтэн дэд мужид хамрагдана. <u>Агаарын температур:</u> Тухайн бүс нутагт жилийн дундаж агаарын температур -4°C орчим байх ба хотын дотор (Тахилт, Улаан хуаран орчим) -1.2 ...-1.5°C, өндөр уулын оройгоор (Хүрэлтогоот, Морин уул) -1...-0.8°C гэж одоо мөрдөж байгаа “Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт. БНБД 2.01.01-93”-д гаргасан байна. Туул голын хөндийд -4...-4.20C, үүнээс ч хүйтэн, уулын энгэр, ээвэр газар -4°C-ээс дулаан, ар хойд талдаа үүнээс ч хүйтэн байх жишээтэй. Агаарын температур уул нуруундаа +14°C-аас сэрүүн, голын хөндий нутагт арай дулаан 14-16°C байна. <u>Агаарын чийгшил, хур тунадас:</u> Харьцангуй чийгшил хамгийн дулаан сарын өдрийн 13 цагт 50-60 % байдаг нь энэ орчим нь өндөр чийгшилтэй нутаг юм. Жилийн дундаж харьцангуй 70-75 % хүрч хуурай хаврын улиралд 45-55 % байна. <u>Нарны цацраг, нарны гийгүүлэл:</u> Улаанбаатар хотод жилдээ 2862-2816 цаг нар гийгүүлэх бөгөөд Богд Хан ууланд дунджаар 2800 цаг нар гийгүүлдэг байна.

	<p><u>Хур тунадас:</u> Хур борооны дундаж эрчим зуны саруудад 0.05 мм/мин, хамгийн их эрчим VII сардаа 1.28 мм/мин байна.</p> <p><u>Салхи, агаарын даралт:</u> Хан Хэнтийн нуруу, Туул голын сав газрын салхи нь хойд, баруун хойноос ноёлох чиглэлтэй. Салхины хамгийн их хурд 5-р сард ажиглагдах ба хамгийн намуун үе нь 12,1-р сард тохиолддог. Салхины дундаж хурд 3,21 м/сек боловч голын хөндийд 4,8 м/сек хүртэл нэмэгддэг. Салхины хурд хаврын 4 сард их 1.4-6.3 м/сек, намар 10 сард 0.8-4.7 м/сек хүрч 10 м/сек-ээс их хурдтай салхи 7-10 өдөр тохиолдох магадлалтай.</p>
Агаар, дуу чимээ	<p>Үйлдвэрлэлийн явцад ялгарах бага хэмжээний утаа нь агаарын чанар, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд маш бага хэмжээгээр сөргөөр нөлөөлж болзошгүй.</p> <p>Тухайн орчны дуу чимээний хэмжилтийг 2019 оны 9 сарын 18-нд хийсэн. Хэмжилтийг төсөл хэрэгжих цэг дээр, байгалийн нөлөө /салхи/, хүний үйл ажиллагааны нөлөө /харилцан яриа, барилгын ажил/ зэрэг хүчин зүйлийг тусган өнөөгийн бодит дуу чимээний түвшнийг тодорхойлсон. Дуу чимээний дундаж утгын түвшин Монгол улсын MNS4585:2017 стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа ба дуу чимээний хамгийн их утга хүнд даацын машины хажууд хийсэн хэмжилт/ Монгол улсын MNS4585:2017 стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан. Энэ нь тухайн үеийн чимээ болон байгалийн буюу салхины нөлөөнөөс болж дуу чимээний түвшин 10-40 дБа-р нэмэгдсэн шалтгаантай, цаашид үйл ажиллагааны явцад техник хэрэгслийн дуу чимээ бусад дагалдах объектуудын орчинд дуу чимээний түвшин суурь фон түвшнээс нэмэгдэнэ, дуу чимээний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага үүснэ.</p>
Ус	Төслийн талбай орчимд гадаргын ил задгай ус байхгүй учир гадаргын усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага байх боломжтой.
Хөрс	<ul style="list-style-type: none"> Төслийн үйл ажиллагааны явцад, машин техникийн хөдөлгөөн зэргээс шалтгаалж тус орчны зарим хэсгийн үржил шимт хөрс элэгдэл, эвдрэлд орох; Машин, техникийн аюулгүй ажиллагаа алдагдах, тослох материалын асгаралт зэрэг нь хөрсөнд шууд нөлөөлөх
Ургамлан	Уурын зуухны ойр орчим нь суурьшлын бүс учраас хөрс эвдрэлд өртөж, үүссэн тоосжилт нь ургамлын бүрхэвч дээр бууж хуримтлагдсанаар ургамлын фотосинтезийн бүтээмжид сөргөөр нөлөөлж урт хугацаанд ургамлын ургах чадварыг алдагдуулах зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй.
Амьтан	Үйлдвэрийн үйл ажиллагааны ойролцоо үйлдвэрийн барилгуудтай төвлөрсөн бүс учраас томоохон зэрлэг амьтад үргэн дайжсан бөгөөд тэдгээрт нөлөөлөл байхгүй
Тусгай хамгаалалттай газар нутаг	Үйлдвэрийн талбай орчимд улсын болоод орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг үгүй болно.

Нийгэм эдийн засгийн төлөв байдлын тодорхойлолт

Нийгэм эдийн засгийн төлөв байдлын тодорхойлолт	
Ерөнхий мэдээлэл	<p><u>Дүүргийн гол онцлог:</u></p> <ul style="list-style-type: none"> Нийслэлд хүн амын тоогоор тэргүүлдэг Нутаг дэвсгэрийн хэмжээ их Хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд их Мал аж ахуй бусдаас илүү Шинжлэх ухааны байгууллага олон Их дээд сургууль олон Цэргийн байгууллага олон Байшин болон гэр хороолол хосолсон <p><u>Нутаг дэвсгэр, газар зүйн онцлог</u></p>

	<p>Баянзүрх дүүрэг 124.4 мянган га газар нутагтай, Богд хан уулын Бага тэнгэр, Богино Хүрхрээ, Чулуут, Бумбат, Залаат, Төр хурахын ам, Хар усан тохой зэрэг ан амьтан, цэцэг жимс, ой мод, рашаан ус, эмийн ургамал бүхий үзэсгэлэнт сайхан байгальтай юм.</p> <p>Гоёмсог барилга, өргөн гудамж, зам талбай , гүүр , хөшөө дурсгал бүхий хотын шинжийг агуулсны сацуу уул толгод, ой хөвч, тал хээрийг багтаасан үзэсгэлэнт байгаль бүхий Нийслэл хотын хамгийн том дүүрэг юм.</p> <p>Дүүргийн нутаг дэвсгэрт 4700 гаруй аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үүнээс 151 нь төсвийн, 420 нь төрийн бус байгууллага бол 18 нь хувьцаат компани, 3345 нь ХХК юм. Мөн төрийн өмчит үйлдвэрийн газар 49, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 13 дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулдаг.</p>
Оршин суугчид	Тус аж ахуйн талбайн хойд талд Юнигаз ХХК-ийн агуулах байрлах ба эргэн тойрон үйлдвэрлэл төвлөрсөн бүс юм. Үйлдвэр талбайн зүүн талд Баянзүрх дүүргийн 10-р хорооны оршин суугчид байх ба “М-Си-Эс Кока-Кола” ХХК-ийн үйлдвэрийн бүсэд ажилчид ажилладаг болно.
Хүний эрүүл мэнд	Тухайн үйлдвэр нь дээрх дурдсан оршин суугчид, ажилчид болон орчны агаарын чанарыг сайжруулах төсөл болж байгаа бөгөөд хүний эрүүл мэндэд нөлөөлөл бага юм.
Бусад төсөл	Дүүргийн нутаг дэвсгэрт 4700 гаруй аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үүнээс 151 нь төсвийн, 420 нь төрийн бус байгууллага бол 18 нь хувьцаат компани, 3345 нь ХХК юм. Мөн төрийн өмчит үйлдвэрийн газар 49, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 13 дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулдаг.

ҮЙЛДВЭРИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Агар Энержи” ХХК-ийн “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэрийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг төслийг хэрэгжүүлэх байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний судалгаагаар тодорхойлсон байдаг.

Үүнд:

Агаарын чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүд

- Хийн алдагдал үүсэх болзошгүй нөхцөл

Усны чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүд

- Байгалийн гамшгийн улмаас бодис материал алдагдсанаас хөрсөнд нэвчин уст үеийг бохирдуулах.

Хөрсний чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүд

- Химийн бодис, тос тосолгооны материал, бохир ус асгарснаас шалтгаалан хөрс бохирдох.
- Хуурай хог хаягдлыг зөвшөөрөлгүй газар хаяснаар хөрс бохирдох.
- Борооны усны угаагдал, үерийн усны улмаас бохирдол зөөгдөн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах.

Аж ахуйн гол сөрөг нөлөөлөл

Түвшин	Зэрэг	Тайлбар		
		Сөрөг нөлөөлөл	Хөрөнгө	Шийдэл
V	Лавтай болох	Ашиглалтын үеийн химийн бодисын хэрэглээ	Н- Дунд хохирол	Үйлдвэрийн технологийн болон химийн бодисын хэрэглээний үеийн зааврыг чанд сахин мөрдөж ажиллах
IV	Магад болох	Химийн бодисын сав, уутны хаягдал үүсэх	М-Бага хохирол	Химийн бодисын сав, уут боловсруулах үйлдвэртэй хамтран ажиллах
III	Болзошгүй	Дуу чимээ, доргионы бохирдол	М-Бага хохирол	Үйлдвэрийн тоног төхөөрөмжид доргио, чичиргээнээс үүсэх нөлөөллийг багасгаж зөөлөвч хийх
I	Бараг болохгүй	Хийн тоног төхөөрөмжийн ашиглалтын явцад үүсэх болзошгүй хий алдагдах, гал түймэр зэрэг нөлөөлөл	Н-Их хохирол	Технологийн аюулгүй байдлыг чанд сахин ажиллах, гэнэтийн аюул ослоос сэргийлсэн автомат аваарын төхөөрөмжүүдийг тоноглолын дамжлага бүрд суурилуулан байнга хянаж ажиллах

1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ АРИЛГАХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Гарсан зардал, төгрөг	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээний хэрэгжилт, баримтжуулсан мэдээлэл
1. Агаарын бохирдлоос хамгаалах ажил					
1	Уурын зуухны агаарт үзүүлэх болзошгүй нөлөөлөл	Уурын зуух болон нүүрсхүчлийн байгууламж доторх агаарын чанар тодорхойлуулах	Уурын зуухны барилга, байгууламж	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардалд оруулсан	Уурын зуух болон нүүрсхүчлийн байгууламж доторх агаарын чанарын шинжилгээг жилд 2 удаа Цаг уур, байгаль орчны шинжилгээний лабораторид хийлгэсэн ба шинжилгээний үр дүнгээр MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлагыг хангаж байна Хавсралт 2. Зураг 1.2 Зураг 1.3
2. Хөрсний бохирдлоос хамгаалах ажил					
2	Байгальд үүсэх болзошгүй асгаралт болон эрсдэл	2.1 Хөрсний хяналт-шинжилгээг улирал бүр заасан цэгт орчимд байнга хийж байх	Үйлдвэрийн талбай	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардалд оруулсан	2023 онд 1 сард БОМТ батлагдсанаас хойш 1,2,3,4-р улиралд Уурын зуухны ойролцоо, нүүрсхүчлийн хийн байгууламж орчим газруудын хөрсний шинжилгээг улирал бүр МУИС хүрээлэн буй орчны хими, геохимийн итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн ба шинжилгээний үр дүнгээр Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019 шаардлагыг хангаж байна. Хавсралт 2. Зураг 2.1-2.4-т шинжилгээ авсан цэгийн байрлал болон шинжилгээний дүнг харуулав.
		2.2 Байгаль орчин, ХАБЭА болон уурын зуухны тоног төхөөрөмж хариуцсан ажилтанг ажиллуулах		Дотоод зардлаас	Үйлдвэрт ХАБЭАБО болон уурын зуухны тоног төхөөрөмж хариуцсан ажилтнуудыг тогтмол ажиллуулж байна. ХАБЭАБО болон уурын зуухны тоног төхөөрөмж хариуцсан ажилтнууд хийн алдагдалгүй, зуухны найдвартай ажиллагаанд хяналт тавьж, сайжруулан ажиллаж байна. Химийн бодисыг асгаралтгүй, аюулгүй ашиглахад химийн бодис

“Агар Энержи” ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт байрших “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэр”-ийн 2023 оны байгаль орчны **2023** менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

					хариуцсан мэргэжилтэн хяналт тавьж ажиллаж байна. Хавсралт 2. Зураг 2.5, 2.6-д хариуцсан ажилчдын ажлын байрны тодорхойлолт. Хавсралт 2. Зураг 2.7-т сайжруулсан баримт бичгүүдийг хавсаргав.
3	Хөрс орчин бохирдуулах үйл ажиллагаа	Технологийн бүх шатанд хоргүйжүүлэх, ариутгах ажиллагааг бүрэн хийж хариуцлагатай ажиллах ба хаягдлыг зохих заавар шаардлагын дагуу, зөвшөөрөгдсөн газарт хаях		Хог хаягдлын менежментийн зардалд оруулав.	Технологийн бүх шатанд химийн бодисын алдагдал гардаггүй бөгөөд Химийн бодисын сав, боодлыг химийн бодисын сав, баглаа боодол, хаягдал хадгалах контейнерт ялган түр хадгалж байгаад дахин боловсруулах эрх бүхий Цэцүүх трэйд компанид хүлээлгэн өгдөг. Ахуйн хог хаягдлыг Кока кола компанийн нэгдсэн хогийн цэгт түр хадгалж хог тээвэрлэх, устгах эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгдөг. Хавсралт 5. Зураг 2.1-2.5
3. Усан орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах 2021-2025					
4	Цэвэр усны хэрэглээ	Үнэлгээний тайланд тусгасны дагуу М-Си-Эс Кока-Кола ХХК-ийн үйлдвэрээс гарах цэвэршүүлсэн бохир усыг үйлдвэрийн зам талбай, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах	Үйлдвэрийн талбай	Дотоод төлөвлөлтөөр	М-Си-Эс Кока-Кола ХХК-ийн үйлдвэрээс гарах цэвэршүүлсэн бохир усыг өөрийн үйлдвэрийн зам талбай, ногоон байгууламжийн усалгаанд тогтмол ашиглаж байна. Цэвэр усыг зөвхөн ариун цэврийн өрөөнд хэрэглэдэг болно. Хавсралт 2. Зураг 4.1
5	Болзошгүй байгалийн гамшгийн аюул	Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Туул голын сав газрын захиргаанаас зохион байгуулагддаг Туул голын сав дагуух “БҮХ НИЙТИЙН ЦЭВЭРЛЭГЭЭ”-нд материал хангамжаар /шуудай, бээлий/ дэмжлэг үзүүлэх		Хог хаягдлын менежментийн зардалд оруулав.	2023 оны 10-р сарын 24-ний өдөр Нийгмийн хариуцлагын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Туул голын сав газрын захиргаанаас зохион байгуулагддаг Туул голын сав дагуух “БҮХ НИЙТИЙН ЦЭВЭРЛЭГЭЭ”-нд материал хангамжаар /150 хос бээлий, 150ш шуудай/ дэмжлэг үзүүлэв. Хавсралт 2. Зураг 5.1
Нийт зардал					

2. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө	Арга хэмжээний цар хэмжээ	Гарсан зардал, төгрөг	Нөхөн сэргээх арга хэмжээний гүйцэтгэл	Баримтжуулсан баримт бичиг
1.	Ногоон байгууламжийг нэмэгдүүлж агаарын бохирдлыг бууруулах	Өмнө тарьсан 10 ш модыг арчлах, услах	Үйлдвэрийн талбай	120,000	Үйлдвэрийн урд болон хойд хэсгийн 40м2 талбайн зүлэг бүхий хэсгийн усалгааг бороогүй үед тогтмол хийв. Үйлдвэрийн урд хэсэгт шинэ хадгалах танк байршуулсан бөгөөд 4 ш модыг шилжүүлж, 6 ш модны усалгааг бороогүй үед тогтмол хийв.	Хавсралт 3 Зураг 1.1
2.	Нийслэлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Хан-Уул дүүргийн 14-р хорооны ногоон бүсийг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд оролцон мод тарих	Хан-Уул дүүргийн 14-р хорооны ногоон байгууламж	Дотоод төлөвлөлтөөр	2023 оны 05-р сарын 13-ны “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд М-Си-Эс Группийн зохион байгуулсан Богд уулын Хүрхрээгийн аманд ойжуулан үржүүлэх, нөхөн сэргээлтийн “Ойжуулъя, нөхөн сэргээе, арчилъя” уриатай 8 төрлийн 3000 мод тарих ажилд оролцож, нийт 100 мод тарив.	Хавсралт 3 Зураг 2.1
Нийт зардал				120,000		

3. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйлдвэрийн талбай орчим нь олон жилийн туршид хүн суурьшиж ирсэн бөгөөд одоог хүртэл хийсэн археологийн судалгаанаас үзвэл түүхийн олдвор, дурсгалт зүйл газар үгүй.

4. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Арга хэмжээний цар, хэмжээ	Гарсан зардал	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээний биелэлт	Баримтжуулсан баримт бичиг
	1	2	3	4	5	
1.	Хийн тоног төхөөрөмжийн буруу ашиглалт	Технологийн заавар, аюулгүй ажиллах журмыг нарийн мөрдөх, хяналтыг сайжруулан шаардлагатай журам, зааврыг сайжруулах	Уурын зуух, Хийн үйлдвэрийн барилга, байгууламж	1,935,000	1.1 Хийн түлш алдагдсан үед авах арга хэмжээний стандарт үйл ажиллагааны заавар гарган, мөрдөж ажиллаж байна. 1.2 2023 оны 07-р сарын 31-ний өдөр хийн үйлдвэрт содын уусмал найруулах үед химийн бодист өртөх, асгарах болон түлэгдэх аюулаас урьдчилан сэргийлж процесс сайжруулалт хийв. Үүнд: Сода найруулах зорилгоор халуун химийн бодисоор савыг дүүргэх түр шланган холболтыг байнгын ган хоолойгоор сольж холболт хийж угсрав. 1.3 2023 оны 06-р сарын 30-ны өдөр хөргөх цамхагийн үзлэгийн шат тавцанг шинээр байршуулж, өндөрт ажиллах үеийн аюул эрсдэлийг бууруулав.	Хавсралт 4 Зураг 1.1 Зураг 1.2 Зураг 1.3
2.	Химийн бодисын хадгалалт, тээвэрлэлтийн явцад учрах эрсдэл	Монголын химич, химийн инженер технологичдын холбооноос зохион байгуулагддаг “Химийн бодистой харьцан ажиллагсдыг чадавхжуулах” сургалтад Химичдийг хамруулах. Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах сургалтыг		300,000	Компанийн химичид нь Монголын хими, химийн инженер технологичдын холбооноос зохион байгуулсан “Химийн бодистой харьцан ажилтнуудыг чадавхжуулах” 2023.11.03-ний өдөр химийн бодистой холбоотой хууль, дүрэм, аюултай хог хаягдлын менежмент, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагууд болон ашиглалт, хадгалалт, тээвэрлэлт сэдвийн хүрээнд 8 цагийн сургалтад хамрагдсан. Химийн бодис хариуцсан мэргэжилтнүүд нь жилд 2 удаа нийт ажилтнуудад “Химийн бодисын аюулгүй ажиллагаа”, “Химийн хорт	Хавсралт 4 Зураг 2.1
				Дотоод төлөвлөлтөөр		Хавсралт 4 Зураг 2.2, 2.3

“Агар Энержи” ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт байрших “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэр”-ийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан **2023**

		дотооддоо ажилтнуудад хийх.			болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах зааварчилгаа” сэдвээр сургалтыг 2023 оны 03 болон 10-р саруудад зохион байгуулав.	
		Химийн бодисын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтад хяналт тавих		Дотоод төлөвлөлтөөр	Химийн бодис хадгалах агуулах нь MNS6458:2014 Хөдөлмөрийн эрүүл ахуй, химийн хорт болон бодисын бүтээгдэхүүний ерөнхий шаардлага, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй ажлын байр дахь гэрэлтүүлгийн хэмжилт зөвшөөрөгдөх хэмжээнд тавигдах шаардлагыг хангасан мэргэжлийн улсын байцаагчийн дүгнэлт авсан бөгөөд “Химийн бодисын ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө”-г ОБГ-аар батлуулан, хэрэгжүүлж байна. Дотооддоо химийн бодис ашиглах, цуглуулах, хаях журам гарган мөрдөж ажилладаг. Мөн химийн бодис хүлээн авах үеийн хяналтыг “Химийн бодисын аюулыг анхааруулах, аюулын тухай санамжийг байршуулсан. зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэдэг /Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам 4.1.2 дахь заалт/-н дагуу хүлээн авах бүрд, химийн бодисын агуулахын хяналтыг 14 хоног тутамд, аюултай хог хаягдлын химийн хорт бодисын хаягдал боловсруулах компанид хүлээлгэн өгч бүртгэл хөтөлдөг.	Хавсралт 4 Зураг 2.4 Зураг 2.5 Зураг 2.6 Зураг 2.7 Зураг 2.8 Зураг 2.9 Зураг 2.10

“Агар Энержи” ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт байрших
 “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэр”-ийн 2023 оны байгаль орчны **2023**
 менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

3.	Химийн бодисын ашиглалтаас үүсэх болзошгүй эрсдэл	Химийн хорт болон аюултай бодисын тооллого хийх	Химийн бодисын агуулах	Дотоод төлөвлөлтөөр	Химийн бодисын тоо хэмжээ, зарцуулалтыг сар бүр гаргадаг ба жил бүрийн химийн бодисын бүртгэл, зарцуулалтын тайланг яамны нэгдсэн системээр хийхээр болсон ба манайх албан ёсоор системд бүртгүүлэн ашигладаг химийн бодисын мэдээллээ бүртгэл хийж байна. Тайлан гаргах үйл явц нь цахим системийн хөгжүүлэлт дуусаагүй байгаатай холбоотой хүлээгдэж байна.	Хавсралт 4 Зураг 3.1 Зураг 3.2
		Ажлын байранд ашиглаж байгаа химийн бодисуудын ХАЛМ-ийг ажлын байрнуудад нэмж байрлуулах		40,000	Химийн бодисын агуулах болон үйлдвэрлэлд ашиглаж байгаа химийн бодис бүрд химийн бодисын ХАЛМ-ийг байршуулж сайжруулав.	Хавсралт 4 Зураг 3.3
		Химийн бодисын асгаралтаас ажлын байр, улмаар хөрс, орчныг бохирдуулахаас сэргийлэх хэрэгсэл шинээр авч байрлуулах		585,000	Химийн бодис хүлээн авах болон Үйлдвэрлэлд химийн бодис нэмэх үеийн химийн бодисын хоёрдогч контейнер буюу асгаралтаас сэргийлэх тосгуурыг 07 болон 09-р саруудад тус тус байршуулав	Хавсралт 4 Зураг 3.4.
4.	Галын аюулгүй байдлаас болж үүсэх болзошгүй эрсдэл	Гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж шинэчлэн сайжруулах	Үйлдвэрийн хэмжээнд	7,915,033	2023 оны 04-р сарын 10-ны өдөр М-Си-Эс Холдинг ХХК-аас галын аюулгүй байдлын урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийдэг. Үзлэгийн хүрээнд илэрсэн зөрчлийг залруулах арга хэмжээ авч, галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх дараах ажлуудыг хийв. Үүнд: 1. Мэргэжлийн байгууллагаар галын дохиоллын автомат системийн самбарын засвар үйлчилгээг 2023 оны 07 сарын 19-ны өдөр хийлгэв. 2. Үйлдвэрийн хэмжээнд Таван-Орд ХХК-ийн иж бүрэн гал унтраах автомат систем суурилуулах ажлын хүрээнд ажлын зураг хийлгэхээр гэрээ хийсэн ба 2023 оны 11 сардаа багтан ажлын зураг бэлэн болно.	Хавсралт 6 Зураг 3.1. Зураг 3.2.

**“Агар Энержи” ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт байрших
“Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэр”-ийн 2023 оны байгаль орчны **2023**
менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

					3. 2023 оны 10-р сарын 01-ний өдөр Цахилгааны өрөөний хуваарилах самбаруудад автомат гал унтраагуур суурилуулсан.
		Нийт зардал		10,775,033	

5. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах чиглэлээрх төлөвлөсөн арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Гарсан зардал, төгрөг	Хог хаягдлын чиглэлээр хийсэн ажлын тайлан	Баримтжуулсан баримт бичиг
1	2	3	4	5	6	7
1.	Болзошгүй байгалийн гамшгийн аюул, бохирдол	Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Туул голын сав газрын захиргаанаас зохион байгуулагддаг Туул голын сав дагуух “Бүх нийтийн цэвэрлэгээ”-нд материал хангамжаар /шуудай, бээлий/ дэмжлэг үзүүлэх	Үйлдвэрийн талбай	528,000	Нийгмийн хариуцлагын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Туул голын сав газрын захиргаанаас зохион байгуулагддаг Туул голын сав дагуух “БҮХ НИЙТИЙН ЦЭВЭРЛЭГЭЭ”-нд материал хангамжаар 2023 оны 10 сарын 24-нд /150 хос бээлий, 150ш шуудай/ дэмжлэг үзүүлэв.	Хавсралт 2 Зураг 5.1.
2.	Үйлдвэрийн хог хаягдал	Химийн бодисын сав, хаягдал боловсруулах үйлдвэрт хаягдал сав, уутыг өгөх Дахин ашиглагдахгүй хог хаягдлыг Хог тээвэрлэх эрх бүхий байгууллагаар зайлуулах		1,664,400	Химийн бодисын сав, боодлыг химийн бодис хадгалах контейнерт түр хадгалж байгаад дахин боловсруулах эрх бүхий Цэцүүх трэйд компанид хүлээлгэн өгдөг. Ахуйн хог хаягдлыг Кока кола компанийн нэгдсэн хогийн цэгт түр хадгалж хог тээвэрлэх, устгах эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгдөг.	Хавсралт 5 Зураг 2.1-2.5
		Нийт зардал		2,192,400		

6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Гарсан зардал, төгрөг	Орчны хяналт шинжилгээний үр дүн	Баримтжуулсан баримт бичиг
	1	2	3	4	5	6
Хөрсний хяналт шинжилгээний хөтөлбөр						
1.	Хөрсний механик бүрэлдэхүүн	2 цэг	Жилд 4 удаа	88,000	2023 онд 1 сард БОМТ батлагдсанаас хойш 1,2,3,4-р улиралд Уурын зуухны ойролцоо, нүүрсхүчлийн хийн байгууламж орчим газруудын хөрсний шинжилгээг МУИС хүрээлэн буй орчны хими, геохимийн лабораториор хийлгэсэн ба шинжилгээний үр дүнгээр Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS5850:2019 шаардлагыг хангаж байна.	Хавсралт 2. Зураг 2.1-2.4
2.	Хөрсний агрохимийн найрлага	2 цэг		88,000		
3.	Хөрсөн дэх хүнд металл	2 цэг		296,000		
Агаарын хяналт шинжилгээний хөтөлбөр						
4.	Агаар дахь тоосжилтын агууламж	2 цэг	Жилд 2 удаа	288,000	Уурын зуух болон нүүрсхүчлийн байгууламж доторх агаарын чанарын шинжилгээг хагас жил тутам Цаг уур, байгаль орчны шинжилгээний лабораторид хийлгэсэн ба шинжилгээний үр дүнгээр MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлагыг хангаж байна	Хавсралт 2 Зураг 1.2 Зураг 1.3
	Нийт зардал			760,000		

7. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Гарсан зардал, төгрөг	Хэрэгжүүлсэн ажил	Баримтжуулсан баримт бичиг
1.	Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар ажил эхлэхийн өмнө сургалт, сурталчилгааг хийх	1,025,000	Шинээр ажилд орсон ажилчдад ажил эхлэхийн өмнөх ХАБЭАБО-н сургалтыг ХАБЭАБО-ы албанаас зохион байгуулдаг. Мөн 2023 онд 14 ажилтан нийт ажилтны ХАБЭА-н сургалтад “Төгс баян хүрээ” ХАБЭА сургалт зөвлөх үйлчилгээний төвийн сургалтад хамрагдав. 2023 оны 06-р сарын 29-ны өдөр Баянзүрх дүүргийн ОБ-ын хэлтэстэй хамтран гамшиг гал түймрээс сэргийлэх дадлага болон танхимын сургалт зохион байгуулж нийт 15 ажилтан оролцов. 2023 оны 06-р сарын 08-ны өдөр М-Си-Эс Кока-Кола ус ундааны үйлдвэртэй хамтран гамшиг осол, аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалтад нийт 8 ажилтан хамрагдав.	Хавсралт 6 Зураг 1.1 Зураг 1.2 Зураг 1.3
2.	Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт сунгуулах	150,000	Баянзүрх дүүргийн онцгой байдлын хэлтсээс ажлын байрны галын аюулгүй байдалд үзлэг, шалгалт хийснээр 2023 оны 05-р сарын 15-ны өдөр ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийг гаргаж, баталгаажуулсан.	Хавсралт 6 Зураг 2.1.
3.	Гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж шинэчлэх, хөдөлмөр хамгаалал, хориглосон үйл ажиллагааны таниулах самбар шинэчлэн сайжруулах	126,500	Компанийн ХАБЭА-н ажилтан Галын аюулгүй байдлын үзлэг шалгалтыг сар бүр хийдэг. Баянзүрх дүүргийн ОБ-ын хэлтэстэй хамтран гал унтраах дадлага хийсэн бөгөөд сургуулилтын үед ашигласан 4кг-н 3 ширхэг галын хорыг 2023 оны 07-р сарын 27-ны өдөр дахин цэнэглүүлж баталгаажуулав. Галын аюулаас урьдчилан сэргийлэх дараах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг байнгын бэлэн байдалд байлгадаг. Үүнд: Үйлдвэрийн хойд болон зүүн хэсэгт 2 галын сарай /Гал унтраах анхан шатны иж бүрдэл/, үйлдвэрт нийт 28 ширхэг гал унтраагуур, 4 ширхэг галын гидрант, 6 ширхэг автомат гал унтраагуур, галын дохиоллын автомат систем суурилагдсан.	Хавсралт 6 Зураг 3.1. Зураг 3.2.
	Нийт зардал	1,301,500		

“Агар Энержи” ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт байрших
 “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэр”-ийн 2023 оны байгаль орчны **2023**
 менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан /ажилтан	Зохион байгуулах газар	Гарсан зардал, төгрөг	Гүйцэтгэл	Баримтжуулсан баримт бичиг
1	2	3	6	7	8			
1.	БЗД-н 10-р хорооны ИНХ-д	Аман илтгэл	Тухайн жилийн БОМТ	Үйлдвэр хариуцсан менежер, ХАБЭА-н ажилтан	Хорооны байр	20,000	БЗД-ийн 10-р хорооны ИНХ, Засаг дарга болон төлөөлөгчдөд 2023 оны БОМТ-ний хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын танилцуулгыг 2023 оны 10-р сарын 26-нд танилцуулав.	Хавсралт 7 Зураг 1.1
2.	Нийслэлийн БОГ-т	Бичгэн тайлан			Нийслэлийн БОГ	120,000	2023 оны төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулан бэлтгэж, Нийслэлийн Байгаль орчны газарт хүргүүлэв.	
3.	БОАЖЯ-д				БОАЖЯ	20,000	2023 оны төлөвлөгөөний биелэлт Нийслэлийн БОГ-аар хянагдаж шалгагдсаны дараа БОАЖЯ-д хүргүүлнэ. 2024 оны БОМТ-г боловсруулж байна.	
Нийт зардал						160,000		

9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ЗАРДЛЫН ЗАДАРГАА

2023 оны менежментийн төлөвлөгөөний биелэлт	Зардлын хэмжээ, төг
Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахад	Давхардсан, дотоод төлөвлөлтөөр
Орчны тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд арга хэмжээ	120,000 + дотоод төлөвлөлтөөр
Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ- Түүх, соёлын өв байхгүй учир арга хэмжээ төлөвлөөгүй.	-
Осол эрсдлийн менежментийг хэрэгжүүлэхэд	10,775,033
Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд	2,192,400
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	760,000
Удирдлага зохион байгуулалтын менежментийн хэрэгжилт	1,301,500 + дотоод төлөвлөлтөөр
БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах	160,000
Нийт дүн	15,308,933

ХАВСРАЛТ 1. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН НҮҮР

БАТЛАВ.

БОАЖЯ-НЫ ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ:



Ч.БАТСАНСАР

ШҮҮМЖ ХИЙСЭН

БОАЖЯ-НЫ ШИНЖЭЭЧ:



Д.ТЭМҮҮЛИН

"АГАР ЭНЕРЖИ" ХХК-ИЙН НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 10-Р
ХОРООНЫ НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ "УУРЫН ЗУУХ БОЛОН
НҮҮРСХҮЧЛИЙН ХИЙН АЖ АХУЙ ГМ СИ ЭС КОКА КОЛА"
ҮЙЛДВЭРИЙГ ТЕХНОЛОГИЙН УУР, ДУЛААН, ХҮНСНИЙ
ЗОРИУЛАЛТТАЙ ХИЙГЭЭР ХАНГАХ / ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ГҮЙЦЭТГЭСЭН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА:

"ГЛОБАЛ ЭНВАЙРОН" ХХК, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ч.ДАВААСҮРЭН

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:

"АГАР ЭНЕРЖИ" ХХК, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.ХҮДЭРХУЯГ

Улаанбаатар хот
2021 он

5 ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НҮҮР

БАТЛАВ:

БОАЖЯ-НЫ ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ:



Ч.БАТСАНСАР

ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“АГАР ЭНЕРЖИ” ХХК, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:



Ч.ХҮДЭРХУЯГ

“АГАР ЭНЕРЖИ” ХХК-ИЙН НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 10-Р
ХОРООНЫ НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ “УУРЫН ЗУУХ БОЛОН
НҮҮРСХҮЧЛИЙН ХИЙН АЖ АХУЙ /М СИ ЭС КОКА КОЛА”
ҮЙЛДВЭРИЙГ ТЕХНОЛОГИЙН УУР, ДУЛААН, ХҮНСНИЙ
ЗОРИУЛАЛТТАЙ ХИЙГЭЭР ХАНГАХ/ ТӨСЛИЙН 5 ЖИЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ /2021-2025/

БОЛОВСРУУЛСАН:

“ГЛОБАЛ ЭНВАЙРОН” ХХК, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:



Ч.ДАВААСҮРЭН

Улаанбаатар хот
2021 он

2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НҮҮР

БАТЛАВ:

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ
БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА

Б. БУЯННЭМЭХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“АГАР ЭНЕРЖИ” ХХК ЗАХИРАЛ

Ц.ХҮДЭРХУЯГ

“АГАР ЭНЕРЖИ” ХХК НИЙ УЛААНБААТАР, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, 10-Р
ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИНЭ. “УУРЫН ЗУУХ БОЛОН
НҮҮРСХҮЧЛИЙН ХИЙН АЖ АХУЙ” ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6423701



ХЯНАСАН:

ХБОБЗГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

ПҮРЭВ. ШИНЭЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:

“АГАР ЭНЕРЖИ” ХХК БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

Э.ЭРДЭНЭБИЛЭГ

2023 ОН

“Агар Энержи” ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт байрших
“Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэр”-ийн 2023 оны байгаль орчны
менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

2023

БАТЛАВ:

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН ДАРГА:

Ц.УРАНЧИМЭГ

ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“АГАР ЭНЕРЖИ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАГ



Э.ХУДЭРХУЯГ

**“АГАР ЭНЕРЖИ” ХХК-ИЙН НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 10-Р
ХОРООНЫ НУТАГТ БАЙРШИЛТАЙ
УУРЫН ЗУУХ БОЛОН НҮҮРСХҮЧЛИЙН ХИЙН ҮЙЛДВЭРИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ХЯНАСАН:

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

П.ШИНЭЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:

“АГАР ЭНЕРЖИ” ХХК-ИЙН ХАБЗА АЖИЛТАН:

A handwritten signature in black ink, appearing to be "Э.Худэрхуяг".

Э.ЭРДЭНЭБИЛЭГ

Улаанбаатар хот
2022 он

ХАВСРАЛТ 2.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН БИЕЛЭЛТ



Зураг 1.1. Хөрсний дээж болон агаарын шинжилгээ авсан цэгүүдийн байршил



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№	: 2023/А-140
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Анар Энержи” ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал	: Б.Сувд агварын хэсэг
Дээжийн тоо, төрөл	: 2 агаар ,2 дуу чимээ
Сорьц авсан огноо	: 2023.06.13
Дээжийн тодорхойлолт	: Улаанбаатар хот БЗД 10-р хороо
Шинжилгээний аргын стандарт	: MNS 17.2.5.12:88, MNS 17.2.5.11:88,DUSTRAK8530
Шинжилсэн огноо	: 2023.06.15
Хуудасны тоо	: 1/1

Үр дүн :

№	Сорьц авсан цаг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Нийт Тоос /TSP/ мг/м ³	Дуу чимээ /ДБА/
1	Үйлдвэрийн гадна талбай	VI/13	14:45	0.015	0.021	0.079	68
2	Зуухны гадна талбай	VI/13	15:10	0.017	0.020	0.083	59
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер:

Хянаж баталгаажуулсан:
Чанарын менежер




Э.Оюунтуяа

Б.Алтантуяа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

Зураг 1.2. Уурын зуух болон нүүрсхүчлийн байгууламжийн агаарын чанарын шинжилгээний үр дүн 2023 оны 6-р сарын 13

Зураг 1.3. Уурын зуух болон нүүрсхүчлийн байгууламжийн агаарын чанарын шинжилгээний үр дүн 2023 оны 11-р сар – тайлан гаргах үед бэлэн болоогүй



**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
 ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ХИМИ, ГЕОХИМИЙН ЛАБОРАТОРИ**

Дээж авсан огноо: 2023.03.30
 Дээж авсан газрын нэр: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Амгалан 13260, Гачууртын зам 104, Уурын зуур, хийн үйлдвэр орчим
 Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "Агар Энержи" ХХК
 Харилцах утас: 88073392

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн

№	Дээжний нэр	pH	Давс, %	ЦДЧ, dSm	Ялзмаг, %	Шингээгдсэн сууриул мг-экв/100гр		Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
						Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
1	Уурын зуух орчим	8.65	0.12	0.79	0.48	8.3	3.4	1.17	14.0
2	Хийн үйлдвэр орчим	8.46	0.10	0.68	0.56	10.1	3.9	1.08	11.0

Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Дээжний нэр	Жишгт хэсгүүдийн эзлэх хэмжээ, хувиар							Механик бүрэлдэхүүний нэр
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01 Физик шавар	
1	Уурын зуух орчим	29.4	28.1	16.8	5.6	10.5	9.6	25.7	Хөнгөн шавранцар
2	Хийн үйлдвэр орчим	27.7	26.8	19.3	5.9	10.2	10.1	26.2	Хөнгөн шавранцар

Хөрсний хүнд металл


№	Дээжний нэр	Хүнд металл, мг/кг					
		Никель/Ni	Кадми/ Cd	Зэс/ Cu	Цайр/ Zn	Хром/ Cr	Хар тугалга/ Pb
1	Уурын зуух орчим	21.3	0.19	10.7	40.8	2.7	11.0
2	Хийн үйлдвэр орчим	21.8	0.20	10.8	40.0	2.6	10.7
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, стандарт		MNS 5850:2019					

Жич: Энэхүү шинжилгээний зарцуулсан үйлдвэр дээжнийг хамрагдах ба хуульбарлан хэрэглэхийг хориглоно.
 Шинжилгээ хийсэн арга, стандарт: MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020, MNS ISO 11466:2007)

Лабораторийн эрхлэгч:  / Ph.D Ц. Соёл-Эрдэнэ /

Шинжилгээ хийсэн:  / О. Билгүүн /

Зураг 2.1. Хөрсний хяналт-шинжилгээний үр дүн 1-р улирал /Уурын зуухны үйлдвэр орчим, Х-1, Хийн үйлдвэр орчим Х-2/



**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ХИМИ, ГЕОХИМИЙН ЛАБОРАТОРИ**

Дээж авсан огноо: 2023.05.17
 Дээж авсан газрын нэр: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Амгалан 13260, Гачууртын зам 104, Уурын зуур, хийн үйлдвэр орчим
 Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "Агар Энержи" ХХК
 Харилцах утас: 88073392

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн

№	Дээжний нэр	pH	Давс, %	ЦДЧ, dSm	Ялзмаг, %	Шингэмдсэн сууриуд мг-эв/100гр		Шим гэжээлийн элементүүд мг/100гр	
						Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
1	Уурын зуух орчим	8.71	0.13	0.84	0.51	8.8	3.8	1.25	15.0
2	Хийн үйлдвэр орчим	8.53	0.12	0.71	0.60	10.2	4.4	1.17	10.0

Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Дээжний нэр	Жижиг хэсгүүдийн эзлэх хэмжээ, хувиар							Механик бүрэлдэхүүний нэр
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01 Физик шавар	
1	Уурын зуух орчим	28.7	28.8	17.5	6.3	9.8	8.9	25.0	Хөнгөн шавранцар
2	Хийн үйлдвэр орчим	27.0	27.5	20.0	6.6	9.5	9.4	25.5	Хөнгөн шавранцар

Хөрсний хүнд металл

№	Дээжний нэр	Хүнд металл, мг/кг					
		Никель/Ni	Кадми/ Cd	Эс/ Cu	Цайр/ Zn	Хром/ Cr	Хар тугалга/ Pb
1	Уурын зуух орчим	21.0	0.22	10.9	44.1	3.2	11.5
2	Хийн үйлдвэр орчим	21.5	0.23	11.0	43.3	3.1	10.9
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, стандарт		MNS 5850:2019					

Жиг: Энэхүү шинжилгээний харуул нь тухайн дээжэнд хэлтгэгдэх ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
 Шинжилгээ хийсэн арга, стандарт: (MNS 3510:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020, MNS ISO 11466:2007)

Лабораторийн эрхлэгч: / Ph.D Ц. Соёл-Эрдэнэ /
 Шинжилгээ хийсэн: / Ө. Билгүүн /



Зураг 2.2. Хөрсний хяналт-шинжилгээний үр дүн 2-р улирал /Уурын зуухны үйлдвэр орчим, Х-1, Хийн үйлдвэр орчим Х-2/



**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ХИМИ, ГЕОХИМИЙН ЛАБОРАТОРИ**

Дээж авсан огноо: 2023.08.14
 Дээж авсан газрын нэр: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Амгалан 13260, Гачууртын зам 104, Уурын зуух, хийн үйлдвэр орчим
 Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "Агар Энержи" ХХК
 Харилцах утас: 88073392

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн

№	Дээжний нэр	pH	Давс, %	ЦДЧ, dSm	Ялзмаг, %	Шингээгдсэн сууриул мг-экв/100гр		Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
						Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
1	Уурын зуух орчим	8.51	0.08	0.91	0.68	9.1	4.9	1.32	14.0
2	Хийн үйлдвэр орчим	8.39	0.06	0.79	0.65	10.7	4.8	1.2	12.0

Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Дээжний нэр	Живинг хэсгүүдийн эзлэх хэмжээ, хувиар							Механик бүрэлдэхүүний нэр
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01 Физик шавар	
1	Уурын зуух орчим	23.4	32.9	16.7	5.5	12.7	8.8	27.0	Хөнгөн шавранцар
2	Хийн үйлдвэр орчим	29.2	31.9	13	6.3	12	7.6	25.9	Хөнгөн шавранцар

Хөрсний хүнд металл

№	Дээжний нэр	Хүнд металл, мг/кг					
		Никель/Ni	Кадми/ Cd	Зэс/ Cu	Цайр/ Zn	Хром/ Cr	Хар тугалга/ Pb
1	Уурын зуух орчим	21.9	0.19	10.1	36.7	2.3	10.5
2	Хийн үйлдвэр орчим	21.7	0.18	10.0	38	2.2	10.0
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, стандарт		MNS 5850:2019					

Жич: Энэхүү шинжилгээний танил үр дүнгийг дээжтэй хамрагдах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно. Шинжилгээ хийсэн арга, стандарт (MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020, MNS ISO 11466:2007)

Лабораторийн эрхлэгч:  / Ph.D Ц. Соёл-Эрдэнэ /

Шинжилгээ хийсэн:  / Ө. Билгүүн /

Зураг 2.3. Хөрсний хяналт-шинжилгээний үр дүн 3-р улирал /Уурын зуухны үйлдвэр орчим, Х-1, Хийн үйлдвэр орчим Х-2/



**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ХИМИ, ГЕОХИМИЙН ЛАБОРАТОРИ**

Дээж авсан огноо: 2023.10.02
 Дээж авсан газрын нэр: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Амгалан 13260, Гачууртын зам 104, Уурын зуух, хийн үйлдвэр орчим
 Дээж шинжилгүүлсэн байгууллага, хувь хүн: “Агар Энержи” ХХК
 Харилцах утас: 88073392

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн

№	Дээжний нэр	pH	Давс, %	ЦДЧ, dSm	Ялэмвг, %	Шингэгдсэн суурьд мг-экв/100гр		Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
						Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
1	Уурын зуух орчим	8.99	0.12	1.01	0.74	9.3	5.3	1.38	18.0
2	Хийн үйлдвэр орчим	8.83	0.10	0.89	0.71	10.9	5.2	1.26	16.0

Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Дээжний нэр	Живинг хэсгүүдийн эзлэх хэмжээ, хувиар						Механик бүрэлдэхүүний нэр	
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001		Физик шавар
1	Уурын зуух орчим	22.9	33.4	17.2	6.2	11.0	9.3	26.5	Хөнгөн шааринцар
2	Хийн үйлдвэр орчим	28.7	32.4	13.5	7.0	10.3	8.1	25.4	Хөнгөн шааринцар

Хөрсний хүнд металл

№	Дээжний нэр	Хүнд металл, мг/кг					
		Никель/ Ni	Кадмий/ Cd	Зэс/ Cu	Цайр/ Zn	Хром/ Cr	Хар тугалга/ Pb
1	Уурын зуух орчим	21.5	0.22	10.5	36.2	2.6	10.3
2	Хийн үйлдвэр орчим	21.7	0.18	10.0	38.0	2.2	10.2
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, стандарт		MNS 5850:2019					

Жаг: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн дээжний хамрагдах ба хуулиарлан хэрэглэхийг хориглоно.
